



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС**



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР**

/2012 он/



Өлгий хот 2013 он

АГУУЛГА

I. Оршил	3
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	4
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7
I.3 Газар тариалангийн салбарын үйлдвэрлэлт	9
II. Мал аж ахуй	
II.2 2012 оны мал тооллогын дүн	10
II.2.1 Малын хэрэглээний зарлага	17
II.2.2 Төл бойжилт	20
II.2.3 Том малын зүй бус хорогдол	24
II.2.4 Иргэдийн малын бүлэглэлт	27
II.2.5 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	28
II.2.6 Малжуулалтын талаар авсан арга хэмжээ	30
II.2.7 Малын тэжээлийн үйлдвэрлэлт, хангамж	30
II.2.8 Малчдын нийгэм, ахуйн үзүүлэлт	32
II.2.9 Малчдын тоо, насны бүлгээр	34
II.2.10 Малтай өрх, малчин өрх	35
II.2.11 ХАА-н салбарын ажиллах хүч	37
III. Газар тариалан	
III.1 Тариалсан талбай	38
III.2 Хураасан ургац	38
IV. Дүгнэлт	40

_____ о О о _____

Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Н.Манаргүл

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: stat-bel@mongol.net

Утас: 70422432 ,70422322

Интернет хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii/](http://www.nso.mn/bayan-ulgii/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2013 оны 6-р сар

РШИЛ

Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2012 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, тэжээлийн тооллогыг 2012 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Малын 2012 оны тооллогын маягтыг өмнөх жилүүдийн тооллогоос арай хураангуй байдлаар өөрчилэн шинэчилж, зааврын дагуу явуулж, үр дүнг нэгтгэн гаргалаа.

Энэхүү танилцуулгад малын 2012 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна мал аж ахуйн салбарын бүтээгдэхүүн, голлох нэр төрлийн түүхий эд үйлдвэрлэлийн хэмжээ, шинээр гаргасан, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.

НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр – 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу- Өмнөх оны төл, 2 настай
Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ.

Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.

100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45,
Хуц, ухна - 25-30

Том малын зүй бүс хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бүс хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бүс хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Тариалангийн талбай . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг

хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

Тариалсан талбай. Тухайн жилд үр суулгасан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Хураасан талбай. Тухайн жилд ургацыг хурааж авсан газрын нийт талбайн хэмжээг хэлнэ.

Га-гийн ургац. Талбайн нэг нэгжээс /1 га-гаас/ авах газар тариалангийн бүтээгдэхүүний /ургацын/ хэмжээ бөгөөд га-гийн ургацыг тодорхойлохдоо тухайн төрлийн ургамлын хурааж авсан бүх ургацыг тариалсан талбайн хэмжээнд нь харьцуулж тодорхойлно.

Нийт ургац. Тухайн жилд газар тариалангийн үйлдвэрлэл эрхэлж үйлдвэрлэсэн нийт бүтээгдэхүүний хэмжээ, өөрөөр хэлбэл, тариалсан бүх талбайгаас хураан авсан үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, малын тэжээл, техник, тосны ургамал зэрэг ургамал тус бүрийн төрлөөр нэмж гаргасан нийт ургацын хэмжээ болно.


ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

2012 онд цаг агаарын байдал тааламжтай байж оны эцэст тоолуулсан малын тоо 8.3 хувиар өсөж хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг 8.3 хувь буюу 3666.6 сая төгрөгөөр өслөө. Өнгөрсөн жилийн цаг агаарын байдлаас шалтгаалж, малын тоо өсөж, зүй бусаар хорогдсон малын тоо буурч, мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн тоо өсөж, мөн малын үнэ болон малын арьс, ширний үнэ өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөнд голлон нөлөөлсөн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ, ХЭМЖЭЭ

	2007	2008	2009	2010	2011	2012	/сая.төг/	
							2012/2011 %	Зөрүү
Бүгд	60621.3	72374.1	79181.3	81623.3	104679.0	113367.5	108.3	8688.5
ХАА, ойн аж ахуй, ан агнуур	37418	40457	44841.6	41309	44174.5	47841.1	108.3	3666.6
ДНБ-ий дүндээ эзлэх хувь	61.7	55.9	56.6	50.6	42.2	42.2	100.0	0.0

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /САЯ.ТӨГ/



Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүний дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ний 60-70 орчим хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөж байна.

Мах, нядалгааны жингээр 2012 онд 5953.7 тн мах, 20722 тн сүү, 212 тн ноолуур, 638.2 тн хонины ноос, 7.7 тн хөөвөр, 9.5 тн хялгас, 34 тн эм ноос, 163.1 мянган ширхэг арьс, шир үйлдвэрлэсэн нь 2011 оныхоос мах 33.6 хувь буюу 3010.6 тн-оор, арьс, шир 32.8 хувь буюу 79.7 мянган ширхэгээр буурч, ноос, ноолуур 12.7 хувь буюу 103.1 тн-оор, сүү 0.7 хувь буюу 147.1 тн-оор нэмэгдлээ.

**МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛТ,
БИЕТ ХЭМЖЭЭГЭЭР**

	2010	2011	2012	2012/2011	
				%	Зөрүү
Мах, нядалгааны					
жингээр, тн	10845.2	8964.3	5953.7	66.4	-3010.6
Тэмээний	128.2	141.7	72.4	51.1	-69.3
Адууны	1515.8	1189.7	842.2	70.8	-347.5
Үхрийн	2596.9	2290.2	1542.5	67.4	-747.7
Хонины	4246	3349.9	2059.3	61.5	-1290.6
Ямааны	2358.3	1992.8	1437.3	72.1	-555.5
Сүү, тн	14461.3	20574.9	20722	100.7	147.1
Ингэний	47.5	69.6	72.6	104.3	3
Гүүний	1121.2	1837.5	2093.7	113.9	256.2
Үнээний	9908.3	13807.3	13778.8	99.8	-28.5
Хонины	1279.5	1429.4	1521.3	106.4	91.9
Ямааны	2104.8	3431.1	3255.6	94.9	-175.5
Ноос, ноолуур, тн	932.1	812.7	915.8	112.7	103.1
Тэмээний ноос	13.9	13.6	14.4	105.9	0.8
Хонины ноос	660.1	578.9	638.2	110.2	59.3
Ямааны ноолуур	208.5	177.2	212	119.6	34.8
Эм ноос	33.4	28.4	34	119.7	5.6
Хөөвөр	7.3	6.6	7.7	116.7	1.1
Хялгас	8.9	8.0	9.5	118.8	1.5
Арьс, мян, шир	402.5	242.8	163.1	67.2	-79.7
Тэмээ	0.3	0.4	0.2	50.0	-0.2
Адуу	10.3	5.5	4	72.7	-1.5
Үхэр	18.7	10.7	7.1	66.4	-3.6
Хонь	173.3	115	71	61.7	-44
Ямаа	167.9	103.5	75	72.5	-28.5
Хурга	21.3	5.1	3	58.8	-2.1
Ишиг	10.7	2.6	2.8	107.7	0.2

ГАЗАР ТАРИАЛАНГИЙН 2012 ОНЫ БҮТЭЭГДЭХҮҮН

(үнэ сая төг)

	Дундаж үнэ (мян.төг)	Бүгд		Хувийн аж ахуй		Бусад	
		тонн	үнэ	тонн	үнэ	тонн	үнэ
Үр тариа							
Буудай	102.2						
Арвай	149.9	34.0	5.1	34.0	5.1		
Овьёос	74.2						
Хөх тариа	175.5	36.0	6.3	24.0	4.2	12.0	2.1
Бусад	150	18.0	2.7	18.0	2.7		
Дүн		88.0	14.1	76.0	12.0	12.0	2.1
Төмс	120	4050	486.0	3887.7	466.5	162.3	19.5
Хүнсний ногоо							
Байцаа	1.2	976.9	1.2	909.1	1.1	67.8	0.1
Манжин	1.1	293.2	0.3	258.4	0.3	34.8	
Лууван	0.9	301.6	0.3	286.8	0.3	14.8	
Сонгино	1.1	50.3	0.1	50.3	0.1		
Сармис	2.5						
Өргөс.хэмх	2.0	31.1	0.1	30.5	0.1	0.6	
Ул. лооль	2.0	32.9	0.1	32.4	0.1	0.5	
Тарвас	1.0						
Бусад	1.2	5.0		5.0			
Дүн		1691.0	2.0	1572.5	1.8	118.5	0.1
Малын тэжээл							
Хадлан	35.0	58394.0	2043.8	56974.0	1994.1	1420.0	49.7
Гар тэжээл	29.9	5477.0	163.8	5477.0	163.8		
Таримал тэжээл	52.0	4865.0	253.0	4418.4	229.8	446.6	23.2
Даршны ургамал	42.3						
Хужир	22.5						
Сүрэл	17.2						
Дүн		68736.0	2460.5	66869.4	2387.6	1866.6	72.9
Жимс, жимсгэнэ							
Чацаргана	746	2.6	1.9	2.6	1.9		
Үхрийн нүд	641						
Алим	330	7.1	2.3	7.1	2.3		
Бусад	720	4.2	3.0	4.2	3.0		
Дүн		13.9	7.3	13.9	7.3		
Дүн			2969.9		2875.3		94.6

2012 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ

Малын тоо. 2012 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 1410.5 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 8.3 хувиар буюу 107717 толгойгоор өслөө. Үүнд тэмээ 200 толгойгоор, адуу 3173 толгой, үхэр 6383 толгой, хонь 67465 толгой, ямаа 30496 толгойгоор тус тус нэмэгдэв. Өнгөрсөн онтой харьцуулахад 2012 онд бүх сумдад малын тоо 2.2-17.9 хувь буюу 1008-14906 толгойгоор өссөн байна.

2012 онд нийт 37.9 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 43.5 хувийг эзэлж байна.


МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР

	2008	2009	2010	2011	2012	/толгойн тоогоор/	
						2012/2011 %	зөрүү
Бодоор /мян.тол/	346.0	295.1	261.0	302.6	326.5	107.9	23.9
Толгойн тоо	1529562	1301457	1126859	1302786	1410503	108.3	107717
Тэмээ	3946	3865	3766.0	3992.0	4192.0	105.0	200
Адуу	59677	50953	43451	48532	51705	106.5	3173
Үхэр	82200	70703	66049	80815	87198	107.9	6383
Хонь	605038	524340	459834	506911	574376	113.3	67465
Ямаа	778701	651596	553759	662536	693032	104.6	30496

МАЛЫН ТОО, СУМААР

	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
						%	зөрүү
Алтай	103443	104208	105123	110788	122834	110.9	12046
Алтанцөгц	86751	46821	40322	51472	59338	115.3	7866
Баяннуур	130758	96686	79979	97183	108243	111.4	11060
Бугат	90636	60299	50307	60706	61714	101.7	1008
Булган	126740	127311	59033	75666	81075	107.1	5409
Буянт	79803	64697	67146	74208	87501	117.9	13293
Дэлүүн	150910	148120	145026	166481	180361	108.3	13880
Ногооннуур	150808	121740	98557	111144	114603	103.1	3459
Сагсай	108774	91545	79535	90859	102663	113.0	11804
Толбо	82966	79011	85398	104146	119052	114.3	14906
Улаанхус	179439	146170	124056	135770	144615	106.5	8845
Цэнгэл	201637	185802	165730	195119	199362	102.2	4243
Өлгий	18940	16506	16421	17243	19556	113.4	2313
Цагааннуур	17957	12541	10226	12001	9586	79.9	-2415
Дүн	1529562	1301457	1126859	1302786	1410503	108.3	107717

МАЛЫН ТОО



2012 онд улсын хэмжээнд нийт 40920.9 мянган толгой мал тоологдсны 3.4 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 1.4 хувь, адуу 2.2 хувь, үхэр 3.4 хувь, хонь 3.2 хувь, ямаа 3.9 хувийг тус тус эзэлж байна.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

	/мян.тол/								
	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2010	2011	2012	2010	2011	2012	2010	2011	2012
Бодоор	261.0	302.6	326.5	8649.5	9476.0	10592.2	3.0	3.0	3.1
Толгойн тоо	1126.8	1302.7	1410.5	32729.5	36335.8	40920.9	3.4	3.6	3.4
Тэмээ	3.7	4.0	4.2	269.6	280.1	305.8	1.4	1.4	1.4
Адуу	43.4	48.5	51.7	1920.3	2112.9	2330.4	2.3	2.3	2.2
Үхэр	66.0	80.8	87.2	2176	2339.7	2584.6	3.0	3.5	3.4
Хонь	459.8	506.9	574.4	14480	15668.5	18141.4	3.2	3.2	3.2
Ямаа	553.7	662.5	693.0	13883.2	15934.6	17558.7	4.0	4.2	3.9

ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

	1990	1995	2000	2005	2006	2007	2008	2009
Малтай өрхийн тоо	13465	14456	15402	15499	15194	15126	14998	14930
Бодоор	220439	365950	340924	313287	344642	370964	344469	293285
Толгойн тоо	607645	1255345	1299891	1312821	1461284	1589765	1523058	1296751
Тэмээ	5012	8445	6943	4283	4252	4283	3943	3863
Адуу	58812	78561	67905	56979	61263	64982	59091	50453
Үхэр	84156	118199	95975	80423	88679	94791	82163	70671
Хонь	299884	606131	611910	553644	598459	637282	601633	521362
Ямаа	159781	444009	517158	617492	708631	788427	776228	650402

	2010	2011	2012	2012/1990		2012/2011	
				%	Өсөлт(-,+)	%	Өсөлт(-,+)
Малтай өрхийн тоо	13862	13858	13520	100.4	55	97.6	-338
Бодоор	253951	293760	326556	148.1	106117	111.2	32796
Толгойн тоо	1122835	1298851	1406887	231.5	799242	108.3	108036
Тэмээ	3764	3989	4190	83.6	-822	105.0	201
Адуу	43077	48160	51326	87.3	-7486	106.6	3166
Үхэр	66019	80785	87154	103.6	2998	107.9	6369
Хонь	457245	504472	572086	190.8	272202	113.4	67614
Ямаа	552730	661445	692131	433.2	532350	104.6	30686


НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ

	2007	2008	2009	2010	2011	2012
Тэмээ	0.3	0.3	0.3	0.3	0.3	0.3
Адуу	4.1	3.9	3.9	3.9	3.7	3.7
Үхэр	5.9	5.4	5.4	5.9	6.2	6.2
Хонь	40.1	39.5	40.4	40.8	38.9	40.7
Ямаа	49.6	50.9	50.0	49.1	50.9	49.1
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0


2012 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 62.6 хувийг хонь, 28.3 хувийг ямаа, 5.9 хувийг үхэр, 2.9 хувийг адууны өсөлт хангасан байна.

Нийт малын сүргийн бүтэцээс харвал 49.1 хувийг ямаа, 40.7 хувь нь хонь, 6.2 хувийг үхэр, 3.7 хувийг адуу, 0.3 хувийг тэмээ тус тус эзэлж байна.

СУМДЫН МАЛЫН ТОО, 2012 ОН, МЯН.ТОЛ



НИЙТ СҮРЭГТ ТАВАН ТӨРЛИЙН МАЛЫН ЭЗЛЭХ ХУВЬ, 2012 ОН



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	1990	1995	2000	2001	2002	2003	2004	2005
Дүн	610244	523087	596729	608769	584396	579504	584869	585170
Ингэ	2749	1037	2102	1912	1672	1544	1430	1061
Гүү	21685	17859	23145	20742	20226	18467	18455	17213
Үнээ	45051	37530	46458	41108	37097	37088	37417	34016
Эм хонь	398136	291993	291630	295682	273099	259297	252584	251504
Эм ямаа	142623	174668	233394	249325	252302	263108	274983	281376

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011 %
Дүн	637726	681498	664758	602941	519337	566233	626572	110.7
Ингэ	1074	1075	1034	1019	1084	1181	1279	108.3
Гүү	18356	18909	17335	16172	13788	14716	15573	105.8
Үнээ	36785	38853	34579	31193	30544	34998	38083	108.8
Эм хонь	271093	283481	269837	243500	213163	226635	260038	114.7
Эх ямаа	310418	339180	341973	311057	260758	288703	311599	107.9

Хээлтэгч мал нийт малын 44.4 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 30.5 хувь, адуун сүргийн 30.1 хувь, үхэр сүргийн 43.7 хувь, хонин сүргийн 45.3 хувь, ямаан сүргийн 45 хувийг тус тус эзэлж байна.

Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50–55 хувь, бог малын хувьд сүргийн 60–65 хувийг эзэлж байвал

зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 38.4, бог малд 45.1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011	
								%	Зөрүү
Дүн	36.6	44.6	51.1	53.5	46.1	43.5	44.4	102.2	1.0
Ингэ	24.8	27.2	26.8	27.1	28.8	29.6	30.5	103.1	0.9
Гүү	26.2	31.7	34.0	37.2	31.7	30.3	30.1	99.3	-0.2
Үнээ	35.9	47.3	48.9	47.2	46.2	43.3	43.7	100.8	0.4
Эм хонь	39.2	46.9	51.5	53.0	46.4	44.7	45.3	101.3	0.6
Эх ямаа	35.5	43.6	52.5	56.2	47.1	43.6	45.0	103.2	1.4

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Сумын нэр	2011	2012	Ү ү н э э с					Оны эхний хээлтэгчид % хэлэх	Өмнөх оноос зөрүү /-,+/
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Алтай	1110	2653	0	64	375	568	1646	2.3	1543
Алтанцөгц	636	3836	0	142	730	1052	1912	3.5	3200
Баяннуур	1064	5070	3	111	167	2084	2705	2.5	4006
Бугат	615	11430	2	339	299	633	10157	2.6	10815
Булган	3453	3168	0	70	145	1777	1176	11.0	-285
Буянт	1940	7312	1	302	747	1701	4561	6.3	5372
Дэлүүн	6352	4696	0	149	621	2188	1738	10.0	-1656
Ногооннуур	19	13739	6	302	1317	385	11729	0.0	13720
Сагсай	787	3964	3	72	153	939	2797	2.1	3177
Толбо	602	4697	0	167	801	473	3256	1.8	4095
Улаанхус	1151	4101	1	34	244	594	3228	2.0	2950
Цэнгэл	295	7628	0	237	979	290	6122	0.4	7333
Өлгий	136	5724	3	347	915	617	3842	1.5	5588
Цагааннуур	1592	911	0	16	57	389	449	34.7	-681
Дүн	19752	78929	19	2352	7550	13690	55318	3.8	59177

ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ

	1990	1995	2000	2001	2002	2003	2004	2005
Дүн	20649	5287	52085	40771	95093	12857	16609	70210
Ингэ	47	23	15	54	58	12	47	26
Гүү	2269	703	5569	2971	5337	1524	1972	3428
Үнээ	1701	822	5859	3494	4873	1739	2207	4242
Эм хонь	9158	1891	11785	9555	22664	3643	3913	11122
Эм ямаа	7474	1848	28857	24697	62161	5939	8470	51392

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011 %
Дүн	15000	35586	105416	90454	105922	7876	59246	752.2
Ингэ	4	20	9	24	40	3	2	66.7
Гүү	1294	2046	5459	3046	3669	557	362	65.0
Үнээ	1263	2472	6499	2282	2514	428	5126	1197.7
Эм хонь	4134	9041	17446	8463	11392	1047	7046	673.0
Эм ямаа	8305	22007	76003	76639	88307	5841	46710	799.7

2012 онд оны эхний төллөх насны хээлтэгч малын 10.5 хувьтай тэнцэх 59246 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2011 оныхоос 51370 толгойгоор буюу 7.5 дахин нэмэгджээ.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 75 хувь буюу 59246 нь хээл хаясан хээлтэгч, үлдсэн 25 хувь буюу 19683 нь сувайрсан хээлтэгч байна.


Сувайрсан малын тоо 2010 оныхоос 75.3 хувь буюу 36291 толгойгоор буурчээ.

СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

	1990	1995	2000	2001	2002	2003	2004	2005
Дүн	19699	7807	22376	21300	37026	13179	15463	26113
Ингэ	1444	41	220	39	46	11	25	19
Гүү	5058	1203	3421	1842	3479	1559	2805	2138
Үнээ	6085	1777	4742	3816	4208	2750	3175	3698
Эм хонь	4384	3014	6896	7835	13758	3492	4434	9425
Эм ямаа	2728	1772	7097	7768	15535	5367	5024	10833

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011 %
Дүн	13943	32706	24603	30953	48167	11876	19683	165.7
Ингэ	17	24	17	3	16	14	17	121.4
Гүү	1480	2101	1908	2086	2493	1181	1990	168.5
Үнээ	2429	4217	4036	3820	4568	2234	2424	108.5
Эм хонь	4155	10556	7317	9097	20293	4027	6644	165.0
Эм ямаа	5862	15808	11325	15947	20797	4420	8608	194.8

ХЭЭЛ ХАЯЛТ, СУВАЙРАЛТ



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	1995	2000	2007	2008	2009	2010	2011	2012	<u>2012</u> 2011 %
Буур	96	67	60	54	68	65	76	105	138.2
Азарга	2617	2429	2053	1800	1558	1264	1551	1566	101.0
Бух	3651	2134	2079	1847	1410	1419	1952	1923	98.5
Хуц	7721	6784	7263	7559	6156	5049	5481	6017	109.8
Ухна	5716	5986	8957	9383	7172	5777	7242	7320	101.1
Дүн	19801	17400	20412	20643	16364	13574	16302	16931	103.9

2012 онд 16931 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2011 оныхоос 3.9 хувь буюу 629 толгойгоор нэмэгдэв.


НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО

	үржлийн норм	2006	2007	2008	2009	2010	2011	2012	<u>2012</u> 2011 %
Ингэ	20-25	17	18	19	15	17	16	12	77.4
Гүү	12-15	10	9	10	10	11	10	10	100.0
Үнээ	35-45	20	19	19	22	22	18	20	111.1
Эм хонь	25-30	39	39	36	39	42	41	43	104.9
Эм ямаа	25-30	39	38	36	43	45	40	43	107.5

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин харин бог малыг хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 43 эм хонь, ямаа ногдож 43.3 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой 2012/ 2011	Хувь 2012/ 2011
	2010	2011	2012	2010	2011	2012		
Бүгд	1126.8	1302.7	1410.5	100.0	100.0	100.0	107.8	108.3
Төл өсвөр насны	333.0	471.8	500.5	29.6	36.2	35.6	28.7	106.1
Ажлын ба бэлтгэл насны	260.9	248.4	266.6	23.2	19.1	18.9	18.2	107.3
Хээлтэгч	519.3	566.2	626.5	46.1	43.5	44.3	60.3	110.6
Хээлтүүлэгч	13.6	16.3	16.9	1.2	1.3	1.2	0.6	103.7

СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР, 2012 ОН**МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2012 ОН**

Сумын нэр	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	хээлтүүлэгч
Алтай	100.0	35.2	20.4	43.1	1.3
Алтанцөгц	100.0	30.7	23.3	44.9	1.1
Баяннуур	100.0	37.0	14.2	47.3	1.5
Бугат	100.0	38.3	14.2	46.0	1.5
Булган	100.0	35.1	20.0	43.7	1.2
Буянт	100.0	35.1	20.3	43.3	1.3
Дэлүүн	100.0	28.8	25.0	44.9	1.3
Ногооннуур	100.0	36.2	21.7	40.7	1.4
Сагсай	100.0	33.8	20.2	44.7	1.3
Толбо	100.0	30.1	28.2	40.3	1.5
Улаанхус	100.0	35.8	19.7	43.2	1.2
Цэнгэл	100.0	39.2	16.4	43.2	1.1
Өлгий	100.0	34.3	14.7	50.3	0.7
Цагааннуур	100.0	48.2	7.2	44.1	0.5
Дүн	100.0	35.6	18.9	44.3	1.2


2012 оны байдлаар нийт малын 35.6 хувь буюу 500.5 мянган толгой нь төл, өсвөр насны мал, 18.9 хувь буюу 266.6 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 44.3 хувь буюу 626.5 мян.толгой нь хээлтэгч мал, 1.2 хувь буюу 16.9 мян.толгой нь хээлтүүлэгч мал байна. 2012 онд нийт малын тоонд хээлтэгчийн эзлэх хувийн жин өмнөх оныхоос 0.8 пунктээр нэмэгдэж, төл, өсвөр насны малын эзлэх хувь 0.6 пункт, ажлын ба бэлтгэл насны мал 0.9 пунктээр, хээлтүүлэгч 0.1 пунктээр тус тус буурсан байна.

Малын хэрэглээний зарлага

2012 онд оны эхний нийт малын 17.6 хувьтай тэнцэх 228642 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2011 оныхоос 2269 толгой буюу 1 хувиар нэмэгдсэн байна. Малтай нэг өрх дундажаар 17 толгой малыг хэрэглээнд

зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 11 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА, ХУВИАР, 2012 ОН



Оны эхний тэмээний 8.1 хувь, адууны 11 хувь, үхрийн 15.3 хувь, хонины 19.4 хувь, ямааны 16.9 хувийг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээнд зарцуулсан малын 92.1 хувийг бог мал, 7.9 хувийг бод мал эзэлнэ.

Сумаар авч үзвэл малаа хэрэглээндээ хамгийн ихээр зарцуулсан Цэнгэл 43.3 мян.тол, Дэлүүн 22.4 мян.тол, Улаанхус 24.4, Ногооннуур 23.1 мянган толгойг тус тус зарцуулав.

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА


Сумын нэр	2010	2011	2012	Ү ү н э э с				
				Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	28669	21702	18432	19	570	1194	9348	7301
Алтанцөгц	21218	5880	10014	23	228	312	3366	6085
Баяннуур	17476	17441	10374	22	331	393	3357	6271
Бугат	15126	10416	11715	4	274	609	4775	6053
Булган	10326	8993	14883	39	347	1103	4409	8985
Буянт	16674	12893	11852	8	192	618	5843	5191
Дэлүүн	46373	26250	22388	26	624	1600	9637	10501
Ногооннуур	40369	22370	23125	42	548	982	8023	13530
Сагсай	27403	17265	14948	16	454	767	7088	6623
Толбо	20613	10754	18680	18	392	780	9058	8432
Улаанхус	54877	25478	24428	57	591	1520	12886	9374
Цэнгэл	39663	40160	43289	48	766	2067	18751	21657
Өлгий	876	4899	2402	1	22	317	839	1223
Цагааннуур	4267	1872	2112	0	14	75	982	1041
Дүн	342178	226373	228642	323	5353	12337	98362	112267


Сумын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2012/2011	
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	%	зөрүү
Алтай	16.6	5.1	9.5	12.5	18.3	16.7	84.9	-3270
Алтанцөгц	19.5	6.0	12.3	14.3	21.4	19.4	170.3	4134
Баяннуур	10.7	5.6	9.4	11.4	12.9	9.8	59.5	-7067
Бугат	19.3	12.5	14.0	19.1	19.3	19.7	112.5	1299
Булган	19.7	7.7	9.5	17.2	25.3	18.9	165.5	5890
Буянт	16.0	5.9	8.5	12.1	15.0	18.8	91.9	-1041
Дэлүүн	13.4	10.4	10.2	14.2	16.3	11.7	85.3	-3862
Ногооннуур	20.8	11.9	12.6	18.7	26.3	19.2	103.4	755
Сагсай	16.5	6.1	10.7	13.1	17.4	16.6	86.6	-2317
Толбо	17.9	23.1	14.7	14.9	18.0	18.4	173.7	7926
Улаанхус	18.0	9.2	12.4	16.8	20.8	15.8	95.9	-1050
Цэнгэл	22.2	8.3	11.9	19.2	23.4	22.3	107.8	3129
Өлгий	13.9	3.4	4.3	10.4	19.9	13.0	49.0	-2497
Цагааннуур	17.6		6.5	16.1	17.4	18.4	112.8	240
Дүн	17.6	8.1	11.0	15.3	19.4	16.9	101.0	2269

2012 оны байдлаар оны эхний нийт төллөх насны хээлтэгчийн 88.6 хувь буюу 501822 толгой эх мал төллөж гарсан төлийн 97.6 хувийг буюу 489680 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2011 оныхоос 2100 толгойгоор буюу 0.4 хувиар нэмэгджээ.

Төл бойжилт

БОЙЖУУЛСАН ТӨЛ, СУМААР, /МЯН.ТОЛ/



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ТОЛГОЙГООР, ОЛОН ЖИЛЭЭР**БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР**

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1990	517616	1050	12040	33989	350970	119567
1995	497763	771	15210	33553	281715	166514
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
2004	524505	547	11917	29467	232859	249715
2005	410257	473	9664	24541	203799	171780
2006	521900	508	12240	28166	231710	249076
2007	539265	443	12402	28270	240525	257625
2008	484506	424	9729	23705	234999	215649
2009	413901	487	8656	22460	207360	174938
2010	357520	420	6726	19061	181318	149995
2011	487580	615	11036	26655	204194	245080
2012	489680	642	12575	26600	217323	232540
2012/2011*100	100.4	104.4	113.9	99.8	106.4	94.9
Зөрүү	2100	27	1539	-55	13129	-12540

Гарсан ботгоны 90.6 хувь, унаганы 96.3 хувь, тугалын 96.8 хувь, хурганы 98.6 хувь, ишигний 96.8 хувийг бойжуулсан байна. Бойжуулсан төл өмнөх оныхтой харьцуулахад тугал 55 толгой, ишиг 12540 толгойгоор буурч ингэ 27, унага 1539, хурга 13129 толгойгоор нэмэгдэснийг дээрх хүснэгтээс харж болно.

Бойжуулсан төлийг сумаар авч үзвэл Цэнгэл суманд бойжуулсан төлийн тоо өнгөрсөн оныхоос 3.5, Толбо суманд 2.8 мянган толгойгоор өссөн бол Дэлүүнд 4.3 мянга, Алтайд 2.9 мянган төлөөр буурсан байна.

2006 онд 100 эхээс 89 төл бойжуулж байсан бол 2007 онд үүнээс 5 толгой төлөөр, 2008 онд 13 төлөөр, 2009 онд 9 төлөөр, 2010 онд 21 төлөөр буюу 33.9 хувиар буурсан бол 2011 онд 2.2 дахин өсөж 100 эх малаас 94 төл авч 2012 онд 100 эх малаас 87 төл бойжуулсан нь өмнөх оныхоос 7.4 хувиар буурчээ. Таван төрлөөр авч үзэхэд 2011 оныхоос ботго 3 төл буюу 3.5 хувь, тугал 11 төл буюу 12.6 хувь, ишиг 13 төл буюу 13.8 хувиар тус тус буурч, унага 6 төл буюу 7.5 хувиар өслөө.

ТӨЛ БОЙЖИЛТ, СУМААР, ТАВАН ТӨРЛӨӨР, 2012 ОН


Сумын нэр	Бүгд	ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ					Бүгд	ХОРОГДСОН ТӨЛ				
		Ингэ	Гүү	Үнээ	Эм хонь	Эм ямаа		Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
Алтай	43970	40	1696	3314	22324	16596	707	5	50	105	217	330
Алтанцөгц	19201	116	515	888	7050	10632	972	5	19	45	357	546
Баяннуур	43502	112	1482	1768	13238	26902	3459	20	45	64	210	3120
Бугат	23886	5	598	1246	10954	11083	260	2	9	15	83	151
Булган	29262	73	941	2326	7972	17950	1283	11	86	135	322	729
Буянт	31030	12	620	1496	17541	11361	343		11	17	145	170
Дэлүүн	53844	34	1464	3032	24166	25148	1845	5	93	149	629	969
Ногооннуур	42730	82	958	1652	12829	27209	1257	3	17	33	255	949
Сагсай	35454	33	1114	1715	18098	14494	706	1	66	92	228	319
Толбо	35893	8	562	1580	19847	13896	116		13	13	59	31
Улаанхус	52500	108	1361	3010	26850	21171	666	4	19	61	262	320
Цэнгэл	79057	80	1510	3810	35747	37910	851	11	42	130	167	501
Өлгий	6763	6	203	1448	1542	3564	55		9	8	21	17
Цагааннуур	4730		30	190	2160	2350	108			8	40	60
Дүн	501822	709	13054	27475	220318	240266	12628	67	479	875	2995	8212

Сумын нэр	Бүгд	Б О Й Ж С О Н Т Ө Л					Төлөлтийн хувь	Бойжилтын хувь	ӨНГӨРСӨН ОНЫ МӨН ҮЕ			
		Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг			Төлийн	хорогдол	Урьд онтой харьцуулсан	Урьд оноос зөрүү(+,-)
Алтай	43263	35	1646	3209	22107	16266	91.3	98.4	747	94.6	-40	
Алтанцөгц	18229	111	496	843	6693	10086	81.6	94.9	568	171.1	404	
Баяннуур	40043	92	1437	1704	13028	23782	86.0	92.0	2537	136.3	922	
Бугат	23626	3	589	1231	10871	10932	89.1	98.9	704	36.9	-444	
Булган	28465	62	855	2191	7650	17707	86.8	97.3	2206	58.2	-923	
Буянт	30687	12	609	1479	17396	11191	93.2	98.9	604	56.8	-261	
Дэлүүн	51999	29	1371	2883	23537	24179	76.8	96.6	2683	68.8	-838	
Ногооннуур	41473	79	941	1619	12574	26260	95.1	97.1	1253	100.3	4	
Сагсай	34748	32	1048	1623	17870	14175	87.7	98.0	422	167.3	284	
Толбо	35777	8	549	1567	19788	13865	89.0	99.7	253	45.8	-137	
Улаанхус	51834	104	1342	2949	26588	20851	87.9	98.7	1021	65.2	-355	
Цэнгэл	78206	69	1468	3680	35580	37409	96.2	98.9	1350	63.0	-499	
Өлгий	6708	6	194	1440	1521	3547	90.0	99.2	70	78.6	-15	
Цагааннуур	4622	0	30	182	2120	2290	96.8	97.7	186	58.1	-78	
Дүн	489680	642	12575	26600	217323	232540	88.6	97.6	14604	86.5	-1976	

100 ЭХЭЭС БОЙЖУУЛСАН ТӨЛ

	1990	1995	2000	2001	2002	2003	2004	2005
Бүгд	62	95	72	76	58	89	90	72
Ботго	36	74	29	33	36	40	38	39
Унага	51	85	45	59	42	69	64	53
Тугал	62	89	65	68	62	81	78	67
Хурга	63	96	80	81	66	91	92	84
Ишиг	60	95	68	74	50	90	91	64

	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2012/2011 %
Бүгд	89	84	71	62	41	94	87	92.6
Ботго	47	41	39	23	42	57	54	94.7
Унага	72	67	51	50	61	80	86	107.5
Тугал	82	76	61	65	75	87	76	87.4
Хурга	92	88	83	77	48	96	96	100.0
Ишиг	88	83	64	51	60	94	81	86.2

Том малын зүй бус хорогдол**ТОМ МАЛЫН ЗҮЙ БУС ХОРОГДОЛ**

